

БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ



2023 ОНЫ III УЛИРАЛ



2022 оны 1 сараас эхлэн төв банкны бодлогын хүү эрчимтэй өсжээ

Инфляц улсын түвшинд сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байсан бөгөөд 2022 оны 6 сард дээд цэгтээ буюу 16.1%-д хүрч түүнээс хойш тогтмол буурч байгаа билээ. Монгол банк инфляцыг бууруулахын тулд сүүлийн жилүүдэд бодлогын хүүгээ хэд хэдэн удаа нэмсэн бөгөөд түүнтэй холбоотойгоор арилжааны банкнууд дагаад зээлийн хүүгээ мөн адил өсгөснийг доорх графикаас харж болно. **Moody's** агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг **B3**, **Fitch Ratings** агентлаг **B** буюу тогтвортой гэж дүгнэсэн бөгөөд энэ нь Монгол Улсыг дунд зэргийн эрсдэлтэй зээлдэгч гэж үзэж байна гэсэн үг.

Бодлогын хүү болон хадгаламж, зээлийн хүү, хувь %




Эх сурвалж: Монголбанк


Банкны салбарын нийт зээлийн үлдэгдэл 2023 оны III улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 14%-иар нэмэгдэв

Уул уурхайн салбар энэ онд өсөлттэй байсан нь бараа, үйлчилгээний эрэлт нэмэгдэж, зээлийн өсөлтийг дэмжжээ. Нийт зээлийн хэмжээ бодит дүнгээр өссөнөөс гадна чанаргүй зээлийн хэмжээ буурсан нь эдийн засагт эерэг нөлөөтэй бөгөөд энэ нь аж ахуйн нэгж, иргэд зээлээ төлөх боломжтой болж хөрөнгө оруулалт нэмэгдэх, эдийн засгийн өсөхөд чухал ач холбогдолтой.

Банкны салбарын нийт зээл, их наяд ₮



Банкны салбарын зээлийн ангилал, хувь %




Эх сурвалж: Монголбанк

Нийт зээлийн өсөлтийн 35%-ийг цалингийн зээлийн өсөлт эзэлж байна

Өмнө жилийн III улиралтай харьцуулахад нийт зээлийн үлдэгдлийн хэмжээ **3.11 их наяд** төгрөгөөр нэмэгдэхэд цалингийн зээл **1.10 их наяд**, тэтгэврийн зээл **642 тэрбум**, үл хөдлөхийн зээл **382 тэрбум**, худалдаа үйлчилгээний зээл **357 тэрбум** төгрөгөөр тус тус өссөн нь чухал нөлөө үзүүлэв. Харин уул уурхайн зээл оны өмнөх үеэс **345 тэрбум** төгрөгөөр буюу **21%** буурсан дүн гарчээ. Энэ онд монголын уул уурхайн компаниуд олон улсын зах зээл дээрх түүхий эдийн үнийн таатай байдал, үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор хүчтэй мөнгөн урсгалыг бий болгож гаднаас санхүүжилт татах хэрэгцээгээ багасгажээ.

ТОП-5 банкнуудын тэргүүлэх салбаруудын зээлийн өсөлт, их наяд ₮



Эх сурвалж: Монголбанк


Нийт банкны хадгаламжийн 37% нь Хаан Банканд байрладаг

Өмнөх жилийн III улиралтай харьцуулахад иргэд ба аж ахуй нэгжүүдийн арилжааны банкнууд дах нийт хадгаламж **2.69 их наяд** төгрөгөөр буюу **16%**-иар өссөн бол харилцах хадгаламж **2.57 их наяд** төгрөгөөр буюу **28%**-иар өссөн дүн гарчээ.

Банкны салбарын хадгаламж ба харилцах данс, их наяд ₮



Банкнууд дах нийт хадгаламжийн салбарт эзлэх хувь, %




Эх сурвалж: Монголбанк, банкнуудын улирлын орлогын тайлан

Зөвхөн өөрийн харилцагчдад мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн болно


Хаан Банкны хөрөнгө салбарынхаа нийт хөрөнгийн 1/3-ийг бүрдүүлжээ

Энэ оны III гуравдугаар улирлын байдлаар банкны салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 7% өсөж **49.55 их наяд** төгрөгт хүрсэн бөгөөд нийт 11 банк үйл ажиллагаа явуулж буйгаас доорх ТОП-5 нийт хөрөнгө салбарын **90%-ийг** бүрдүүлж байна. Хас банкны нийт хөрөнгө нэг жилийн дотор хамгийн их хувиар буюу **24%-иар** өссөн бол Хаан банкны нийт хөрөнгө хамгийн их хэмжээгээр буюу **2.90 их наяд** төгрөгөөр өсжээ. Харин Төрийн банкны хөрөнгө хамгийн бага өсөлт үзүүлсэн бөгөөд **440 тэрбум** төгрөгөөр буюу жилийн өмнөх үеэс **12%-иар** өссөн байна.

ТОП-5 банкнуудын нийт хөрөнгө, их наяд ₮



Салбарын нийт хөрөнгө банкнуудаар, %




Эх сурвалж: Монголбанк, банкнуудын улирлын орлогын тайлан


Хэрэглээний зээлийн эрэлт өссөн нь банкнуудын нийт зээлийг өсгөжээ

Хас банкны нийт зээл нэг жилийн дотор хамгийн их хувиар буюу **31%**-иар өссөн бол Хаан банкны нийт зээл хамгийн их хэмжээгээр буюу **1.20 их наяд** төгрөгөөр өсжээ. Харин Худалдаа Хөгжлийн Банк хамгийн бага өсөлт үзүүлсэн бөгөөд **196 тэрбум** төгрөгөөр буюу жилийн өмнөх үеэс **5%**-иар өссөн байна. Хаан банк мөн адил зах зээлийн гурваны нэгийг эзэмшсэн хэвээр байгаа бол ТОП-5-аас бусад **6** банкнуудаар зах зээл дээрх нийт банкны зээлийн **14%** нь олгогджээ.

ТОП-5 банкнуудын нийт зээл, их наяд ₮



Салбарын нийт зээл банкнуудаар, %




Эх сурвалж: Монголбанк, банкнуудын улирлын орлогын тайлан

Банкнудын хуримтлагдсан ашиг өссөнөөр өөрийн хөрөнгө нэмэгджээ

Хас банкны өөрийн хөрөнгө нэг жилийн дотор хамгийн их хувиар буюу **30%**-иар өссөн бол Хаан банкны өөрийн хөрөнгө хамгийн их хэмжээгээр буюу **416.68 тэрбум** төгрөгөөр (**27%**) өсжээ. Харин Төрийн банкны өөрийн хөрөнгө хамгийн бага өсөлт үзүүлсэн бөгөөд **57.59 тэрбум** төгрөгөөр буюу жилийн өмнөх үеэс **13%**-иар өссөн байна.

ТОП-5 банкнудын өөрийн хөрөнгө, их наяд ₮




Эх сурвалж: Банкнудын улирлын орлогын тайлан

Банкнудын хүүгийн орлогын өсөлтийг дагаад ашиг нэмэгдсэн байна

Голомт банкны цэвэр ашиг нэг жилийн дотор хамгийн их хувиар буюу **66%**-иар өссөн бол Хаан банкны цэвэр ашиг хамгийн их хэмжээгээр буюу **72.33 тэрбум** төгрөгөөр (**21%**) өсжээ. Харин Төрийн банкны ашиг өмнөх жилийн мөн үеэс **27.20 тэрбум** төгрөгөөр буюу **31%**-иар буурсан дүн гарчээ.

ТОП-5 банкнудын цэвэр ашиг, тэрбум ₮




Эх сурвалж: Банкнудын улирлын орлогын тайлан

Төрийн банкны эздийн өмчийн өгөөж буюу ROE дөрвөн улирал дараалан буурчээ

Эздийн өмчийн өгөөж буюу ROE үзүүлэлт нь хөрөнгө оруулагчийн оруулсан хөрөнгө хэдэн хувийн ашиг авчирсныг харуулдаг. Голомт банкны ROE 15%-иас 19% болж өсөхөд цэвэр ашиг өөрийн хөрөнгөөс илүү нэмэгдсэн нь нөлөөлжээ. Харин Төрийн банкны ROE өмнө оны мөн үетэй харьцуулахад 14% болж буурсан нь цэвэр ашиг өөрийн хөрөнгөөс илүү буурсантай холбоотой байв.

ТОП-5 банкнуудын ROE, хувь %




Эх сурвалж: Банкнуудын улирлын орлогын тайлан

Төрийн банкны нийт хөрөнгийн өгөөж буюу ROA 1.78% болж буурчээ

Олон улсад банкнуудын ROA-ийг 1% -иас 2% хооронд байхад хэвийн гэж үздэг. Хаан банкны тус үзүүлэлт хамгийн өндөр буюу 3.56% байгаа нь бусдаасаа харьцангуй бага хэмжээний хөрөнгөөс их хэмжээний ашиг олох боломжтойг харуулж байна. Харин Төрийн банкны III улирлын цэвэр ашиг буурсан нь ROA буурахад нөлөөлжээ.

ТОП-5 банкнуудын ROA, хувь %




Эх сурвалж: Банкнуудын улирлын орлогын тайлан

Р/В харьцаа хувьцааны зах зээлийн үнийг нэгж хувьцаанд ноогдох өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа юм

Хаан ба Худалдаа Хөгжлийн банкны 2023 оны III улирлын хувьцааны зах зээлийн үнэ дансны үнээсээ дээгүүр буюу үнэтэй байсан бол Голомт ба Төрийн банкны хувьцааны үнэ өөрийн хөрөнгөөсөө бага буюу хямд байна. Харин Хас банкны хувьцаа ханш өөрийн хөрөнгийн нэгж хувьцаанд ноогдох үнэтэйгээ тэнцүү байна.

ТОП-5 банкнуудын РВ




Эх сурвалж: Банкнуудын улирлын орлогын тайлан

Хаан банкны хураамж шимтгэлээс олсон орлого нийт орлогын 13%-ийг бүрдүүлсэн нь бусад банкнуудтай харьцуулахад хамгийн өндөр байв

Хаан банкны татварын дараах ашиг өмнөх оны мөн үеэс 21%-иар өсөхөд хүүгийн орлого 49%-иар өссөн нь гол үүрэг гүйцэтгэсэн бол хүүгийн бус орлого ердөө 2%-иар өсжээ. Хадгаламжид төлсөн хүү өмнөх оны мөн үеэс 52%-иар өссөн нь хүүгийн зардал 90%-иар өсөхөд ихээхэн нөлөөлжээ.

Хаан банкны 2023 оны III улирлын орлогын тайлан




Эх сурвалж: Хаан банкны улирлын орлогын тайлан

Худалдаа хөгжлийн банкны зардал буурснаар ашиг өссөн байна

Худалдаа хөгжлийн банкны нийт орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад өсөөгүй боловч бусад зардал 26%-иар буурсан нь татварын дараах ашиг өмнөх оны мөн үеэс 38%-иар өсөхөд хүргэсэн байна. Бусад зардал дундаас ханш үнэлгээний тэгшитгэлийн зардал 88.82 тэрбум төгрөг байснаас 2.53 тэрбум төгрөг болж буурсан нь ашиг өсөхөд голлон нөлөөлсөн байна.

Худалдаа хөгжлийн банкны 2023 оны III улирлын орлогын тайлан




Эх сурвалж: Худалдаа хөгжлийн банкны улирлын орлогын тайлан

Голомт банкны татварын дараах ашиг ТОП-5 банкнууд дундаас хамгийн ихээр буюу 66% өсжээ

Голомт банкны хүүгийн ба хүүгийн бус орлого хоёулаа өмнөх жилийн мөн үеэс өссөн нь нийт орлого 57%-иар өсөхөд нөлөөлжээ. Бусад орлого 93%-иар өсөхөд арилжааны орлого 216%-иар өссөн нь нөлөөлсөн бол зээлийн хүүгийн орлого 31%-иар, үнэт цаасны хүүгийн орлого 73%-иар нэмэгдсэн нь хүүгийн орлого 47%-иар өсгөв.

Голомт банкны III улирлын орлогын тайлан




Эх сурвалж: Голомт банкны улирлын орлогын тайлан

Хас банкны нийт орлогын 89%-ийг хүүгийн орлого бүрдүүлжээ

Хас банкны цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс 29%-иар өссөн нь хүүгийн орлого 35%-иар нэмэгдсэнтэй холбоотой. Гэвч хүүгийн орлого өндөртэй банкнууд зээлийн хүүгийн өөрчлөлтөд илүү өртөмтгий байдаг ба хэрэв зээлийн хүү өсвөл зээлийн өртөг өсөж ашиг буурах эрсдэлтэй байдаг. Энэ нь үйлчлүүлэгчдийг татаж хадгалахад хүндрэл учруулж болзошгүй юм. Дээрээс нь энэ жил Хас банкны бусад орлого 3%-иар буурсан нь төрөлжсөн орлогын эх үүсвэртэй бусад банкуудтай харьцуулахад зээлээс бусад банкны үйлчилгээний өрсөлдөх чадвар сул байгааг харуулж байна.

Хас банкны III улирлын орлогын тайлан




Эх сурвалж: Хас банкны улирлын орлогын тайлан

Төрийн банкны зээлийн хүүгийн орлогоос хэт хамааралтай байдал цэвэр ашигт сөргөөр нөлөөлжээ

Хас банктай адил Төрийн банкны хүүгийн орлогын нийт орлогод эзлэх хувь өндөр буюу **88%** байгаагаас гадна энэ жил хангалттай сайн өсөөгүй ба бусад орлого энэ жил **3%**-иар буурсан зэрэг нь цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс **31%**-иар буурахад нөлөөлжээ. Банкны орлогын эх үүсвэрийн төрөлжилт бага байх нь ямар эрсдэл дагуулдгийг Төрийн банкны жишээнээс харж болохоор байна.

Төрийн банкны III улирлын орлогын тайлан



Эх сурвалж: Төрийн банкны улирлын орлогын тайлан

Санамж

Энэхүү мэдээлэл нь Ард Секюритиз ҮЦК-иас зөвхөн мэдээллийн зорилгоор бэлтгэгдсэн болно. Илэрхийлсэн үзэл бодол нь зөвхөн шинжээчийн байр суурийг илэрхийлэх бөгөөд зах зээл болон бусад хүчин зүйлсийн нөлөөллөөр өөрчлөгдөх боломжтой юм. Бүх мэдээ, мэдээллүүд нь үүнд Ард Секюритиз ҮЦК-ийн эх сурвалж болгосон буюу гаргасан мэдээлэл үнэн бодит гэж үзсэн эх сурвалжаас авсан боловч нарийвчлал нь баталгаажаагүй болно. Өнгөрсөн үзүүлэлт нь ирээдүйн үр дүнгийн баталгаа болохгүй. Тиймээс та өөрт нийцсэн хөрөнгө оруулалт эсвэл арилжаа хийхдээ бие даан буюу өөрийн зөвлөхтэйгөө зөвшилцөж шийдвэр гаргах хэрэгтэй гэдгийг анхаарна уу!



Бэлтгэсэн: Д. Гантуяа
Хөрөнгө оруулалтын шинжээч

Утас: 9963 1005
И-мэйл: gantuya.d@ardsecurities.com